Баянлиг сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 12/01 дугаар тогтоолоор төсвийг 424,431.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгон 2,485,336.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 10/01 дугаар тогтоолоор анх баталсан 2,060,904.9 мянган төгрөгийг сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 12/01 тогтоолоор төсвийг 424,431.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,485,336.0 мянган төгрөгийн төсөв баталсан.

Нийт зардлын 506,414.5 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 790,115.3 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 593,014.2 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 4,200.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 550,883.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 24,476.0 мянган төгрөгийг ОНХС-ийн орлогоос, 16,232.5 мянган төгрөгийг ХХС-ийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн санхүүгийн дэмжлэгээр 790,115.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 100% авсан, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн орлогоос 593,014.2 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 15,181.2 мянга, малын хөлийн татварын орлогын санхүүжилтээс 1,032.4 мянган төгрөгөөр тус тус дутуу авсан байна. хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг 6,738.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, оны эцэст зардлын хэмнэлтээс 20,974.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 13. Байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр             | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү  | Хувь | ОН-ын төсөвт төвлөрүүлсэн | Улсын төсөвт төвлөрүүлсэн |
|------------------------------|------------|-----------|--------|------|---------------------------|---------------------------|
| Засаг даргын Тамгын газар    | 578,737.0  | 578,737.0 | 0.0    |      | 2,616.5                   | 0.0                       |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 105,098.4  | 105,133.4 | (35.0) |      | 7,152.6                   | 0.0                       |
| Ерөнхий боловсролын сургууль | 336,056.7  | 336,056.7 | 0.0    |      | 5,970.5                   | 0.0                       |

**Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

|                           |             |             |           |          |     |
|---------------------------|-------------|-------------|-----------|----------|-----|
| Цэцэрлэг                  | 49,930.9    | 49,930.9    | 0.0       | 1,335.4  | 0.0 |
| Эрүүл мэндийн төв         | 87,210.7    | 87,210.7    | 0.0       | 2,383.2  | 0.0 |
| Соёлын төв                | 85,502.8    | 85,502.8    | 0.0       | 1,516.6  | 0.0 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 1,015,991.2 | 1,012,027.6 | 3,963.6   |          | 0.0 |
| Хоршоо хөгжүүлэх сан      | 226,808.3   | 233,546.8   | (6,738.5) |          | 0.0 |
| Нийт дүн                  | 2,485,336.0 | 2,254,599.1 | 2,809.9   | 20,974.7 | 0.0 |

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баянлиг сумын байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,933,921.5 мянган төгрөг буюу 77.8 хувьтай байгаа нь Хоршоо хөгжүүлэх сангаас 226,808.3 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн бөгөөд 120,280.0 мянган төгрөгийн зээл олгосон, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 85,769.9 мянган төгрөгийн мал нядалгааны цэг барих, 57,057.4 мянган төгрөгийн бэлчээрийн менежмент сайжруулах генератор худалдан авах төсөл арга хэмжээний батлагдсан төсөв хүрэлцээгүйгээс төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, 115,000.0 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээ тендер зарласан боловч оролцогч ирээгүйгээс дээрх төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 15,744.8 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт өгснөөс бараа үйлчилгээний зардалд 14,811.1 мянган төгрөг зарцуулж, биет бус хөрөнгө худалдан авахад 629.9 мянган төгрөгийг зарцуулж оны 303.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 14. Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлага, төвлөрүүлэлт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт   | ЗДТГ            | ИТХ            | НИЙТ            |
|--|-----------------|----------------|-----------------|
| <b>НИЙТ ОРЛОГО</b>   | <b>14,444.8</b> | <b>1,300.0</b> | <b>15,744.8</b> |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,776.8        | 1,300.0        | 14,076.8        |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 1,668.0         | 0              | 1,668.0         |
| <b>НИЙТ ЗАРЛАГА</b>  | <b>14,141.4</b> | <b>1,299.6</b> | <b>15,441.0</b> |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр   | 13,511.5        | 1,299.6        | 14,811.1        |
| Хөрөнгийн зардал   | 629.9           | 0              | 629.9           |

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянлиг сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, дарга тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх албан бичгийг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 1/39 дүгээр албан бичгээр ирүүлж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн байна.

Сумын Засаг даргаар О.Мөнхбат, санхүүгийн албаны даргаар Ш.Хоролсүрэн ажилласан байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2023 оны батлагдсан төсөв 2,485,300.0 мянган төгрөгийн 1.5 хувь буюу 24,853.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,397.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Баянлиг сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй болно.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 158 мэдээллээс 156 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт 18. Шилэн дансны мэдээлэл

| д/д | Хугацаа    | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|-----|------------|-------|----------------------|--------------------|-------------------|------------------|
| 1   | Бүтэн жил  | 12    | 12                   | -                  | -                 | 2                |
| 2   | Хагас жил  | 3     | 3                    | -                  | -                 | -                |
| 3   | Улирал бүр | 2     | 8                    | -                  | -                 | -                |
| 4   | Сар бүр    | 5     | 60                   | -                  | -                 | -                |
| 5   | Тухай бүр  | 7     | 73                   | -                  | -                 | -                |
|     | Нийт       | 29    | 156                  | -                  | -                 | 2                |

Эх сурвалж.Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2023 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба жилийн эцсээр дүнг нэгтгэн танилцуулсан болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 35,388.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж, хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 139, 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 117, 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 283 дугаар албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 19. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж

/ мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                          | Өмнөх оны илрүүлэлт |                 | Биелэлт  |                 | Биелэгдээгүй |          | Хэрэгжилтийн хувь |
|-----------------------------------|---------------------|-----------------|----------|-----------------|--------------|----------|-------------------|
|                                   | Тоо                 | Дүн             | Тоо      | Дүн             | Тоо          | Дүн      |                   |
| Зөвлөмж                           | 4                   | 35,388.0        | 4        | 35,388.0        | -            | -        | 100               |
| Хариуцлага тооцох албан шаардлага | 1                   | 0               | 1        | 0               |              |          | 100               |
| <b>Нийт</b>                       | <b>5</b>            | <b>35,388.0</b> | <b>5</b> | <b>35,388.0</b> | <b>-</b>     | <b>-</b> | <b>100</b>        |

Эх сурвалж: Шийдвэрийн хэрэгжилт

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварт аймгийн ОНХС-аас 170.0 сая төгрөгийн засварын хөрөнгө батлагдаж эрх шилжсэн бөгөөд дээрх хөрөнгөөр сумын ЗДТГ, ЭМТ, Цэцэрлэгт засвар хийсэн тул Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хийх гүйцэтгэлийн аудитаар шалгах.

#### 4.7 Аудитын гол асуудал

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баянлиг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 5 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Тус сум нь 13 нэр төрлийн орлогоор 506,414.5 мянган төгрөг төвлөрүүлэхээс 524,624.3 төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 103.6 хувь буюу 18,209.8 мянган төгрөгөөр давж биелсэн бөгөөд орлогын нэр төрлөөр авч үзвэл 5 нэр төрлийн орлого 36,718.2 мянган төгрөгөөр давж биелсэн, 8 нэр төрлийн орлого 20,922.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Баянлиг сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо |            |                           |                    |          | Аудитын санал дүгнэлтийн төрөл |           |                |          |                                  |          |
|------------------|------------------|------------|---------------------------|--------------------|----------|--------------------------------|-----------|----------------|----------|----------------------------------|----------|
|                  | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Гүйцэтгэсэн               |                    |          | Бүгд                           | Үүнээс    |                |          |                                  |          |
|                  |                  |            | Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | сан      |                                | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг    | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан | ан       |
| ЗДТГ             | 1                | 1          |                           |                    | 1        |                                |           |                |          |                                  |          |
| ИТХурал          | 1                | 1          |                           |                    | 1        |                                |           |                |          |                                  |          |
| ОНХС             | 1                | 1          |                           |                    | 1        |                                |           |                |          |                                  |          |
| ХХС              | 1                | 1          |                           |                    | 1        |                                |           |                |          |                                  |          |
| <b>НИЙТ ДҮН</b>  | <b>4</b>         | <b>4</b>   |                           |                    | <b>4</b> | <b>0</b>                       | <b>0</b>  | <b>0</b>       | <b>0</b> | <b>0</b>                         | <b>0</b> |

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл



Сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 139,319.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7,110.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 132,209.8 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №16. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

| Байгууллагын нэр                          | Нийт алдаа зөрчлийн дүн |           | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт |         |                         |     |                       |           |               |     |
|---|-------------------------|-----------|---|---------|-------------------------|-----|-----------------------|-----------|---------------|-----|
|   |                         |           | Залруулга   |         | Тогтоосон төлбөрийн акт |     | Өгсөн албан шаардлага |           | Өгсөн зөвлөмж |     |
|   | Тоо                     | Дүн       | Тоо   | Дүн     | Тоо                     | Дүн | Тоо                   | Дүн       | Тоо           | Дүн |
| Санхүүгийн тайлангийн зөрчил              |                         |           |   |         |                         |     |                       |           |               |     |
| ЗДТГ                                      | 1                       | 9,453.9   | -   | -       | -                       | -   | 1                     | 9,453.9   | -             | -   |
| ОНХСан                                    | 4                       | 20,860.0  | 2   | 7,000.0 | -                       | -   | 2                     | 13,860.0  | -             | -   |
| ХХС                                       | 2                       | 35,110.0  | 1   | 110.0   | -                       | -   | 1                     | 35,000.0  | -             | -   |
| СТА зөрчлийн дүн                          | 7                       | 65,423.9  | 3   | 7,110.0 | -                       | -   | 4                     | 58,313.9  | -             | -   |
| СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал |                         |           |   |         |                         |     |                       |           |               |     |
| ЗДТГ                                      | 1                       | 73,895.9  | -   | -       | -                       | -   | 1                     | 73,895.9  | -             | -   |
| Нийцлийн аудитын дүн                      | 1                       | 73,895.9  | -   | -       | -                       | -   | 1                     | 73,895.9  | -             | -   |
| Нийт дүн                                  | 8                       | 139,319.8 | 3   | 7,110.0 | -                       | -   | 5                     | 132,209.8 | -             | -   |

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлөөс санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 65,423.9 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 73,895.9 мянган төгрөгийн 1 зөрчил тус тус илэрсэн байна. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хавсралтад харуулав.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,922.6 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 20,922.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

### 5.1 Албан шаардлага

5.1.1. Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 103.6 хувь буюу 18,209.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч газрын төлбөр 3,405.2 мянга, иргэний орлого тодорхойлох орлогоор 7,997.8 мянга, галт зэвсгийн албан татвар 15.0 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 3,430.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 600.0 мянга, малын тоо толгойн албан татвар 1,032.4 мянга, газрын дуудлага худалдааны орлого 2,802.2 мянга, хүү торгуулийн орлого 1,640.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.1 дэх “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар”, 23.8.2 дахь “галт зэвсгийн албан татвар”, 23.8.8 дахь “түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр”, 23.8.14 дэх “газрын төлбөр”, 23.8.15 дахь “малын тоо толгойн албан татвар”, 23.8.16 дахь “энэ хуулийн 23.6.11-т зааснаас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар” гэсэн заалтыг зөрчин, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Сумын төсөвт төвлөрөх албан татварыг тайлант хугацаанд нь төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод, хяналт хариуцлагатай холбоотой асуудал.

**Илрүүлэлт:** Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн түүврийн аудитаар нийт 139,319.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7,110.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 132,209.8 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийг мөрдөж Засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад тавих хяналт, төсвийн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                 | Үүнээс        |          |                 |                 |          |          |
|--|-------------|-----------------|---------------|----------|-----------------|-----------------|----------|----------|
|  |             |                 | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |                 | Зөвлөмж  |          |
|  | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн             | Тоо      | Дүн      |
| Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 103.6 хувь буюу 18,209.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч газрын төлбөр 3,405.2 мянга, иргэний орлого тодорхойлох орлогоор 7,997.8 мянга, галт зэвсгийн албан татвар 15.0 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 3,430.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 600.0 мянга, малын тоо толгойн албан татвар 1,032.4 мянга, газрын дуудлага худалдааны орлого 2,802.2 мянга, хүү торгуулийн орлого 1,640.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна. | 1           | 20,922.6        | -             | -        | 1               | 20,922.6        | -        | -        |
| Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн түүврийн аудитаар нийт 139,319.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7,110.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 132,209.8 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.   | 1           | 0               | -             | -        | -               | -               | 1        | -        |
| <b>Дүн</b>   | <b>2</b>    | <b>20,922.6</b> | <b>-</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>20,922.6</b> | <b>1</b> | <b>-</b> |

### Хавсралт 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн

/мянган төгрөгөөр/

|                              |              |   |                                     |
|------------------------------|--------------|---|-------------------------------------|
| Огноо<br>2024                | Аудитын нэр: | Баянлиг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит | Аудитын код:<br>БНА-2024/14/СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: |              | Баянлиг сумын Засаг дарга   | Мянган төгрөг                       |

**Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

| №   | Алдаа, зөрчлийн товч утга  | Мөнгөн дүн       | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                        |
|---|--|------------------|---------------------------------------|---|------------------------|
|   |  |                  |                                       | Албан тушаал                                      | Овог нэр               |
| A   | 1  | 2                | 3                                     | 4   | 5                      |
| <b>Харьяа төсвийн байгууллагуудын дүн</b>                               |  | <b>139,319.8</b> |                                       |   |                        |
| <b>Засаг даргын тамгын газар</b>  |  | <b>83,349.8</b>  |                                       |   |                        |
| <b>Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл</b>                   |  |                  |                                       |   |                        |
| 1   | Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөд 13,100.0 мянган төгрөг батлагдсан бөгөөд нийт нөөц хөрөнгийн 72.0 хувь буюу 9,453.9 мянган төгрөгийг шагналд зарцуулсан байна.  | 9,453.9          | Албан шаардлага                       | Дарга, нягтлан бодогч                             | Г.Мөнхсүх, С.Мөнхцэцэг |
|   | Дүн  | 9,453.9          |                                       |   |                        |
| <b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> |  |                  |                                       |   |                        |
| 1   | Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 3 гэрээг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 514,634.4 мянган төгрөгийн 37 гүйлгээ мэдээлэхээс 74,895.2 мянган төгрөгийн 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 17,677.9 мянган төгрөгийн 2 гүйлгээ мэдээлэхээс 12,113.3 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.   | 73,895.9         | Албан шаардлага                       | Дарга, нягтлан бодогч                             | Г.Мөнхсүх, С.Мөнхцэцэг |
|   | Дүн  | 73,895.9         |                                       |   |                        |
| <b>Орон нутгийн хөгжлийн сан</b>  |  | <b>20,860.0</b>  |                                       |   |                        |
| <b>Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл</b>                    |  |                  |                                       |   |                        |
| 1   | Гамшгаас хамгаалах дадлага сургуулилтын төсөл арга хэмжээний хүрээнд "Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хувцас нийлүүлэх гэрээ"-г "Далай ээж" ХХК-тай 2023.12.21-ны өдөр байгуулсан байна. Гэрээнд 2024.03.15-ны дотор хүлээлгэж өгөхөөр тохиролцон урьдчилгаа 7,000,000.0 төгрөгийг шилжүүлсэн байгааг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.   | 7,000.0          | Залруулга хийх                        | Засаг дарга, Нягтлан бодогч                       | О.Мөнхбат, С.Мөнхцэцэг |
| 2   | ОНХС-ийн батлагдсан төсөл арга хэмжээний хүрээнд "Хог ачих машин худалдах авах" 66,825,000 төгрөгийн гэрээг байгуулж гэрээний техникийн тодорхойлолтод заасны дагуу моторын багтаамж 6000-8000 байх гэж заасан боловч гүйцэтгэгч компаниас хүлээлгэн өгөхдөө моторын багтаамж 4720, С,Евро3 багтаамжтай ба энэ нь ачааны машин, хог ачих авто машины моторын багтаамж өөр байх ёстой техникийн тодорхойлолтоор ачааны машины багтаамжаар гаргасан байна.       | 0                | Залруулга хийх                        | Засаг дарга, Нягтлан бодогч                       | О.Мөнхбат, С.Мөнхцэцэг |
|   | Дүн  | 7,000.0          |                                       |   |                        |
| <b>Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл</b>                   |  |                  |                                       |   |                        |
| 1   | Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 19,800,000 (Арван есөн сая найман зуун мянга) төгрөг бүхий 2023-2032 оны эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил гүйцэтгэх гэрээг 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэхээр "Бат бөх өргөө" ХХК-тай гэрээ байгуулж урьдчилгаа 13,860,000 (Арван гурван сая найман зуун жаран мянган) төгрөг олгосон боловч одоогоор ямар нэгэн ажил хийгдээгүй байна. | 13,860.0         | Албан шаардлага                       | Засаг дарга, Нягтлан бодогч                       | О.Мөнхбат, С.Мөнхцэцэг |
| 2   | Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 9,536,200 төгрөг бүхий "Хичээлийн байрны болон дотуур байрыг бүрэн камержуулж хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил гүйцэтгэх" гэрээг "НСН" ХХК-тай 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан ба 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдөр камержуулалтын ажлыг хүлээн авсан байна. Камержуулалтын ажлаас Ерөнхий боловсролын сургуульд дотоод 16 камер суурилуулсны 2 нь ажиллахгүй байна.   | 0                | Албан шаардлага                       | Засаг дарга, Нягтлан бодогч                       | О.Мөнхбат, С.Мөнхцэцэг |
|   | Дүн  | 13,860.0         |                                       |   |                        |
| <b>Хоршоо хөгжүүлэх сан</b>   |  | <b>35,110.0</b>  |                                       |   |                        |
| <b>Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл</b>                    |  |                  |                                       |   |                        |
| 1   | Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 онд 120,280,000 төгрөгийн зээл авсан 4 аж ахуйн нэгж, иргэний зээлийн эргэн төлөлтийг 2023.12.12-ны байдлаар шалгахад 2 иргэн 110,054 төгрөгийн зээлийн хүүг дутуу төлсөн байгаа нь зээлдэгтэй байгуулсан гэрээний 3.4 дэх заалт, ХХААХҮ-ийн сайдын "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах,   | 110.0            | Залруулга хийх                        | Засаг дарга, Нягтлан бодогч                       | О.Мөнхбат, С.Мөнхцэцэг |

**Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

| №   | Алдаа, зөрчлийн товч утга  | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                        |
|---|--|------------|---------------------------------------|---|------------------------|
|   |  |            |                                       | Албан тушаал                                      | Овог нэр               |
|   | эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 6.9 дахь заалтыг зөрчсөн байна.   |            |                                       |   |                        |
|   | Дүн  | 110.0      |                                       |   |                        |
| <b>Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл</b> |  |            |                                       |   |                        |
| 1   | ХХС-ийн зээлдэгч Б.Долгорсүрэн 2023.05.09-ний өдөр зээлийн гэрээ байгуулан 35,000,000 төгрөгийн зээл авч төсөлд тусгасан 23,000,000 төгрөгийн "Хулдаасан хэвлэлийн машин"-ийг худалдан аваагүй байгаа нь зээлийн гэрээний 3.1.3 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. | 35,000.0   | Албан шаардлага                       | Засаг дарга, Нягтлан бодогч                       | О.Мөнхбат, С.Мөнхцэцэг |
|   | Дүн  | 35,000.0   |                                       |   |                        |

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 269/АОС71/21  
БНА-2024/14/НА-СТА-ТТЗ

Номгон

Г Зөрчил арилгуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 103.6 хувь буюу 18,209.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч газрын төлбөр 3,405.2 мянга, иргэний орлого тодорхойлох орлогоор 7,997.8 мянга, галт зэвсгийн албан татвар 15.0 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 3,430.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 600.0 мянга, малын тоо толгойн албан татвар 1,032.4 мянга, газрын дуудлага худалдааны орлого 2,802.2 мянга, хүү торгуулийн орлого 1,640.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь "Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.8.1 дэх "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар", 23.8.2 дахь "галт зэвсгийн албан татвар", 23.8.8 дахь "түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр", 23.8.14 дэх "газрын төлбөр", 23.8.15 дахь "малын тоо толгойн албан татвар", 23.8.16 дахь "энэ хуулийн 23.6.11-т зааснаас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан

5040819

зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянлиг сумын Засаг дарга О.Мөнхбат, Санхүү албаны дарга Ш.Хоролсүрэн нарт даалгав .

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>1</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

АУДИТОР:

**Н.БАТЧИМЭГ**

<sup>1</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно